Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн
захирлын 20 ... оны ... .. сарын ... өдрийн
... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН СУРАЛЦАГЧДЫН ДҮРЭМ

Зорилго: Суралцагчид хичээл сурлагадаа хариуцлагатай хандах, дадал чадвартай болох, амьдрах ухаан, бие даан суралцах арга барил, харилцаа, гоо зүй, ёс суртахууны өндөр соёлд суралцаж, өөрийгөө болон бусдыг хүндэлдэг, төлөвшсөн, хүмүүнлэг, манлайлагч иргэн болж хүмүүжихэд энэхүү дүрмийн зорилго оршино.

Нэг. Нийтлэл үндэслэл

1.1.МСҮТ-ийн суралцагч сургалт, хүмүүжлийн болон өөрийгөө хөгжүүлэх ажилдаа энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2.Монгол улсын Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль-д заасан эрх үүрэг, сургуулийн дотоод дүрэм, журмыг хэрэгжүүлэх, сураглцагч сурч боловсрох, авьяас чадвараа хөгжүүлэх, тэдний эрх үүргийг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Суралцагчийн мөрдөх зарчим

2.1.Бие даан амьдрах чадвар бүхий, мэргэжлийн ур чадвартай иргэн болон төлөвшихийн төлөө хичээнгүйлэн суралцана.

2.2.Хүн төрөлхтний болон өөрийн ард түмний дэвшилтэт зан заншил, өв уламжлалаас байнга суралцаж хүмүүнлэг ёсыг эрхэмлэнэ.

2.3.Багш, эцэг эх, ахмад хүмүүс, найз нөхдөө хүндэтгэн, тэдний зөвлөгөө, сургамжийг сонсоно.

2.4. Хууль ёсыг хүндэтгэн биелүүлж, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, тамхи татах татах зэрэг ёс суртахуунгүй нийгмийн сөрөг үзэгдлийг цээрлэнэ.

Гурав: Суралцах үеийн мөрдөх дэг

3.1.Хичээл эхлэхээс 5-аас доошгүй минутын өмнө ангид орж, хичээлийн бэлтгэлээ бүрэн хангасан байна.

3.2.Хичээл, дадлагын үед суралцагч дүрэмт хувцас болон хөдөлмөр хамгааллын хувцсыг бүрэн, зөв өмссөн байна.

3.3.Ямар нэгэн шалтгаанаар ээлжит хичээлд орох боломжгүй бол энэ тухайгаа анги удирдсан багшид мэдэгдэж, шаардлагатай бол магадлагаа ирүүлнэ.

3.4.Хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээлээс чөлөө авах тохиолдолд сургалтын албанд хандан бичгээр өргөдөл гаргана.

3.5.хичээлийн завсарлагаанаар хичээлээс хожимдох, хичээлийн явцад ангиас гарах тохиолдолд хичээл зааж буй багшаас зөвшөөрөл авна.

3.6. I, II цагийн завсарлагаанаар суралцагчид ангиас гарахгүй байх.

3.7.Хичээллэх үед гар утас, таблет, чихэвч хэрэглэхгүй байх.

3.8.Хичээлд анхааралтай, идэвхтэй оролцож, багш болон нөхөдтэйгээ хамтран ажиллаж, хичээлийн агуулгыг бүрэн эзэмшихийн төлөө чармайна.

3.9.Сургуулийн болон ангийн эд хогшил, сургалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ном, сурах бичгийг ариг гамтай хэрэглэнэ.

3.10.Өөрийн авьяас сонирхол, хэрэгцээнд тулгуурлан хичээлээс гадуурх дугуйлан секцэд суралцан, сургуулийн захиргаа болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.

3.11.Сургалтын явцад багшаас өгсөн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар, журмыг чанд мөрдөж ажиллана.

3.12. Сургалтын орчинд бусадтай зөв харилцах, ёс бус үг, хэл амаар доромжлох үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх

3.13. Суралцагч нь анги дэвших шалгалт өгч байхдаа бусадтай ярилцахгүй, эргэн тойрон харахгүй, өөрийн болон бусдын анхаарлыг сарниулахгүй байх

Дөрөв : Суралцагч нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ

4.1.Суралцагч нь Боловсролын тухай хуулийн 43.2, 45.1, Мэргэжлийн боловсролын тухай хуулийн 17.1–д заасан эрхийг эдэлж, Боловсролын тухай хуулийн 45.2, Мэргэжлийн боловсролын тухай хуулийн 17.2–д зааснаас гадна үйлдвэрлэлийн дадлагын ажлын үед аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журам, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, Мэргэжлийн боловсролын тухай хуулийн 11.4-т заасан гэрээний заалтыг сахин биелүүлэх үүрэгтэй.

4.2. суралцагч нь Засгийн газраас тогтоосон журмын хүрээнд сургалтын тэтгэлгийг нэг хичээлийн жилд 10 хүртэл сарын хугацаанд авах эрхтэй

4.3. Суралцагч нь сургалтын байгууллагын дотоод журам, суралцагчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн, хичээлийн жилийн хуваарийн дагуу тухайн сарын онолын болон дадлагын сургалтад 75-аас доош хувийн ирцтэй байвал засгийн газраас тогтоосон тэтгэлэгт хамрагдахгүй болно.

4.4.Сургалт, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, интернет, номын сан, биеийн тамирын заал, дадлагын газрыг зохих журмын дагуу сургалтын болон үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар тогтоосон хуваарийн хүрээнд ашиглах.

4.5.Сургууль, бүс, улсын хэмжээнд зохиогдсон ажил мэргэжлийн болон урлаг, спортын уралдаан, тэмцээнд оролцох.

4.6.Зохиосон үлгэр загвар, урласан бүтээсэн бүтээгдэхүүнээ хамгаалах баталгаажуулах.

4.7.Сургуулийн үйл ажиллагаатай холбогдсон аливаа асуудлын талаар санал, хүсэлт, гомдол, шүүмжлэлийг чөлөөтэй илэрхийлэх.

4.8.Оюутны болон суралцагчдын өөрөө төлөөлөн удирдах зөвлөлд сонгох, сонгогдох.

Тав: Суралцагчдад хүлээлгэх хариуцлага

5.1.Суралцагч нь сургалтын явцад үүргээ биелүүлээгүй тохиолдолд шат дараалсан арга хэмжээ авна.

5.2.Суралцагч тухайн улирлын судалбал зохих нийт цагийн 25%-ийг шалтгаангүйгээр тасалсан тохиолдолд анги хамт олны хурлаар хэлэлцэж, шийдвэрийг эцэг эх, асран хамгаалагчид мэдэгдэнэ.

5.3.Суралцагч нь тухайн улирлын судалбал зохих нийт цагийн 25%-иас илүү цагийг шалтгаангүйгээр тасалсан, өвчтэй, чөлөөтэй тохиолдолд Засгийн газраас тогтоосон тэтгэлэг олгох журамд заасан эрх эдлэхгүй, ба хичээл тасалсан шалтгаан нөхцөлийг нь багш нарын хурлаар хэлэлцүүлж, эцэг эх, асран хамгаалагчид шийдвэрийг мэдэгдэнэ.

5.4.Суралцагч нь тухайн улиралд орж буй хичээлийн 40 хувиас дээш сурлагын чанараа хангалтгүй үнэлүүлсэн тохиолдолд багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, эцэг эх, асран хамгаалагчид шийдвэрийг мэдэгдэнэ.

5.5.Суралцагч нь ёс суртахуунгүй үйлдэл, эс үйлдэл гаргах, бусдын бие махбодь, сэтгэл санаа, эд хөрөнгөд санаатайгаар хохирол учруулсан тохиолдолд санал гомдлыг үндэслэн сургуулиас чөлөөлөх хүртэлх арга хэмжээ авна.

5.6. Сургалтын үргэлжлэх хугацаанд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр удаа дараа хаяг байрлал нь тодорхойгүй болсон тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэж, сургуулийн дотуур байр, сургуулиас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

5.7.Суралцагч тамхи хэрэглэсэн тохиолдолд “зорилтот бүлэг”-т хамруулж нөлөөллийн ажилд оролцуулна.

5.8. Суралцагч сургалтын орчинд согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх мансууруулах бодис, түүнтэй ижил үйлчилгээтэй бусад төрлийн химийн найрлага бүхий бодис хэрэглэсэн, хэрэглэхийг завдсан тохиолдолд сургууль, сургуулийн дотуур байрнаас чөлөөлөх хүртэл арга хэмжээг авна

5.8.Суралцагч нь захиргааны хүндэвтэр зөрчлийн шинжтэй, эрүүгийн шинжтэй гэмт хэрэгт оролцсон тохиолдолд сургуулиас чөлөөлөх арга хэмжээ авна.

5.9.Сургуулийн болон дотуур байрны эд, аж ахуйд хохирол учруулсан бол хохирлыг зах зээлийн ханшаар нөхөн төлүүлнэ.

Харилцааны дэг

- ✓ Өглөө бүр Мэндэлье
- ✓ Үеийн нөхдөө ч Хүндэлье
- ✓ Өрөөл бусдадаа Талархъя

- ✓ Өөрөөрөө бас Бахархъя

Цэгцтэй зөв завсарлая

- ✓ Хүлээцтэй байя
- ✓ Хүндэтгэлтэй байя
- ✓ Хариуцлагатай байя

Хичээллэх үеийн дэг

- ✓ Зорилготой байя
- ✓ Идэвхтэй бай
- ✓ Санаачилгатай байя

Эрүүл мэндийн дэг

- ✓ Зөв хандлага
- ✓ Зөв хүмүүжил
- ✓ Зөв төлөвшил
- ✓ Зөв хэвшил

Сургуулийн захиргаа